

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2022 оны Худалдан авах ажиллагааны тайлан

Манай компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 23-ний өдрийн 637 тоот тогтоолоор 11,767,1 сая төгрөгөөр батлагдсан.

Үүний дагуу компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 83/02 тоот тогтоолоор Хөрөнгө оруулалтын 8,567,1 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний төсөл арга хэмжээг зохион байгуулахаар баталсан ба 3,200,0 сая төгрөгийн төсөл арга хэмжээ нь гадаадын зээлээр хэрэгжих ажил болно.

Төлөвлөгдсөн 65 багц худалдан авалтаас жилийн эцсийн байдлаар 53 багц худалдан авалтыг 6,956,1 сая төгрөгөөр амжилттай зохион байгуулж гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна. /Бүлэг тус бүрээр задаргааг харуулав/

/сая.төг/

Д/Д	Тухайн жилд худалдан авах бараа, ажил үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ	Тоо хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Хэмнэлт	Хэрэгжээгүй ажлууд
1	Орон нутгийн салбарын технологийн барилга	23	1,588,7	17	1,251,3	33,8	303,5
2	Цамхаг	2	847,4	2	819,0	28,4	-
3	Үндсэн сүлжээний өргөтгөл	4	4,952,1	3	1,669,3	82,7	3,200,0
4	Өгөгдлийн сүлжээний өргөтгөл	4	105,8	4	93,0	12,7	-
5	Сувагчлал, худаг, кабель шугам, шилэн кабель өргөтгөл	21	1,024,7	18	922,2	47,4	55,0
6	Технологийн багаж, техник хэрэгсэл	3	1,539,6	2	711,4	41,5	786,7
7	Зай тэжээлийн шинэчлэл, хөргөлтийн тоног төхөөрөмж	5	1,418,3	4	1,204,5	65,1	148,6
8	Программ хангамж	3	290,1	3	285,1	5,0	-
	Дүн	65	11,767,1	53	6,956,1	316,9	4,494,0

2022 онд хэрэгжээгүй 4,494,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл арга хэмжээнээс 3,200,0 сая төгрөгийн гадаадын зээлээр хэрэгжих төсөл хойшилсон ба бусад арга хэмжээ нь гэрээ цуцалсан, тендерт санал ирээгүйн улмаас хэрэгжээгүй болно.